



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 5/28.

Ховд

Г Д.Оюунбулгааг ажилд түр томилох тухай Г

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2, 29.1.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 01 дүгээр зөвлөмжийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын Нэгдсэн эмнэлгийн даргын сонгон шалгаруулалтыг Төрийн албаны тухай хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулах хүртэлх хугацаанд тус эмнэлгийн даргаар Даваагийн Оюунбулгааг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн түр томилсугай.
2. Д.Оюунбулгаад Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтын Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээний ТҮЭМ-8-ын 3 дахь шатлал 973 165 төгрөг /есөн зуун далан гурван мянга нэг зуун жаран таван/-өөр цалинжуулж, бусад нэмэгдлийг холбогдох хууль, журмын дагуу үндсэн цалингаас тооцож олгохыг тус эмнэлгийн нягтлан бодогч /Ц.Сүхбат/-д зөвшөөрсүгэй.
3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Д.Оюунбулгаад үүрэг болгосугай.
4. Д.Оюунбулгаад ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг томилж, ажлыг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хүлээлцүүлэхийг Булган сумын Засаг дарга Ж.Дамдинбазар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Заг В/23 Кн
02 2396